

ДОТООДЫН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**



2026.07.27

Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Нийлүүлэлтийн шалтгаантай инфляцын дарамт хэвээр байна.
- 2026 оны эхний хагас жилд төсвийн алдагдал 2.1 их наяд төгрөгт хүрэв.
- ТОП-5 банкны 2026 оны эхний хагас жилийн үзүүлэлт
- ХасБанк ХК 9 тэрбум төгрөгийн хувьцаа эргүүлэн худалдан авна

МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	-	-0.77%	-3.40%
MSE A	-	-0.12%	-2.54%
MSE B	-	0.20%	-1.22%
2026/07/20 – 2026/07/24			

Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Үнийн дүн
INV	1,224,892,630.00
AARD	665,793,216.00
KHAN	661,309,923.00
BDS	417,837,933.00
GLMT	151,961,781.00
2026/07/20 – 2026/07/24	

Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
MGLA	290.00	26.92%
MIB	69.00	15.00%
MNG	3,438.00	14.98%
BTG	54,200.00	14.83%
BUK	248.00	14.81%
2026/07/20 – 2026/07/24		

2026 он 07-р сарын 27

Зах зээлийн
үнэлгээ тэрбум ₮

13,637

ТОП-20 индекс

52,626

MSE A

20,293

MSE B

14,187



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

7.9%

2026 - I улирал

Инфляц

12%

2026-06 сар

ГВУН(сая\$)

7,656.16

2026-06 сар

Бодлогын

хүү

12.0%

ЗГ-ын бондын
өгөөж

5.3%

USD/MNT

3,590.58

2026-07-26




Эдийн засгийн мэдээлэл

НИЙЛҮҮЛЭЛТИЙН ШАЛТГААНТАЙ ИНФЛЯЦЫН ДАРАМТ ХЭВЭЭР БАЙНА

2026 оны эхний хагас жилийн байдлаар хэрэглээний үнийн индекс (ХҮИ) өмнөх оны мөн үеэс 12.0 хувиар өссөн нь инфляцын дарамт өндөр түвшинд хадгалагдаж байгааг харуулж байна. Үнийн өсөлтөд хамгийн их нөлөө үзүүлсэн бүлэг нь хүнсний бүтээгдэхүүн бөгөөд хүнсний үнэ өмнөх оны мөн үеэс 24.8 хувиар өссөн нь нийт инфляцын өсөлтийн гол хүчин зүйл болсон байна.

График: Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт /өмнөх оны мөн үетэй харьцуулахад/




Богино хугацаанд мах, хүнсний ногоо, шатахууны үнэ өндөр хэвээр байх тул инфляц 2027 оны эхэн хүртэл Төв банкны зорилтот интервалаас давсан түвшинд хадгалагдах төлөвтэй байна.

2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ТӨСВИЙН АЛДАГДАЛ 2.1 ИХ НАЯД ТӨГРӨГТ ХҮРЭВ

2026 оны эхний хагас жилийн байдлаар улсын төсвийн тэнцэл 2.1 их наяд төгрөгийн алдагдалтай гарсан нь төсвийн зарлагын өсөлт орлогын өсөлтөөс давсан байгаатай холбоотой байна. Тайлант хугацаанд улсын төсвийн нийт орлого өмнөх оны мөн үеэс 10.7 хувиар нэмэгдэж 14.6 их наяд төгрөгт хүрсэн боловч нийт зарлага 20.0 хувиар өсөж 16.8 их наяд төгрөг болсон нь төсвийн алдагдлыг нэмэгдүүлэхэд голлон нөлөөлжээ.

График: Улсын төсвийн гүйцэтгэл /их наяд төгрөг/



Зарлагын бүтцийг авч үзвэл хөрөнгө оруулалтын зардал хамгийн өндөр өсөлттэй гарч өмнөх оны мөн үеэс 1.6 дахин нэмэгдсэн байна. Мөн бараа, үйлчилгээний болон урсгал шилжүүлгийн зардал өссөн нь нийт төсвийн зарлагыг тэлэхэд чухал нөлөө үзүүлжээ. Харин орлогын өсөлт нь НДШ-ийн орлого, нэмэгдсэн өртгийн албан татвар болон орлогын албан татварын орлогын нэмэгдлээр голлон дэмжигдсэн боловч зарлагын хурдацтай өсөлтийг бүрэн нөхөж чадаагүй байна.



Зах зээлийн мэдээлэл

ТОП-5 БАНКНЫ 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2026 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангаас харахад Монголын банкны салбар өсөлтөө хадгалсан хэвээр байна. Харин ашигт ажиллагааны үзүүлэлт банк бүрийн хувьд харилцан адилгүй гарчээ.

Төрийн банкны цэвэр ашиг өмнөх оны мөн үеэс 105.3%-иар нэмэгдэж, хамгийн өндөр өсөлт үзүүлсэн байна. Үүний эсрэгээр Голомт банкны цэвэр ашиг 37.6%, Худалдаа Хөгжлийн банкных 36.1%-иар буурчээ. Харин Хаан банк болон Хас банкны ашиг бага зэрэг өссөн нь үйл ажиллагаа харьцангуй тогтвортой байсныг харуулж байна.

Хүснэгт: Санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд /тэрбум төгрөг, өмнөх оны мөн үетэй харьцуулсан өөрчлөлт/


	 ГОЛОМТ БАНК	 ХААН БАНК	 ХАСБАНК	 ТУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК	 ТӨРИЙН БАНК
Цэвэр ашиг	134 ▼37.6%	357 ▲1.0%	88 ▲2.7%	71 ▼36.1%	64 ▲105.3%
Цэвэр зээл	8,730 ▲10.3%	15,894 ▲22.8%	4,885 ▲16.0%	8,230 ▲7.0%	4,322 ▲16.4%
Өөрийн хөрөнгө	1,732 ▲21.1%	2,776 ▲13.8%	911 ▲15.6%	1,658 ▲11.1%	718 ▲16.5%
Нийт хөрөнгө	19,860 ▲32.9%	28,083 ▲31.2%	7,508 ▲11.2%	17,703 ▲13.8%	7,784 ▲28.0%

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж


Өөрийн хөрөнгийн өгөөжийн хувьд Хаан банк 12.9%-тай гарч, салбарын 8.7%-ийн дунджаас мэдэгдэхүйц өндөр түвшинд байна. Харин Худалдаа Хөгжлийн банк 4.3%-иар хамгийн доогуур үзүүлэлт үзүүлсэн байна.

График: Санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд


Өөрийн хөрөнгийн өгөөж
(ROE)



Чанаргүй зээлийн харьцаа
(NPL)



Үнэ ба дансны үнийн харьцаа
(P/B)



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж, Голомт Капитал ҮЦК-ийн тооцоолсноор

Чанаргүй зээлийн харьцааг авч үзэхэд Хас банк 2.2%-ийн түвшинтэй гарсан нь зээлийн багцын чанар сайтай, эрсдэл харьцангуй бага байгааг илтгэнэ. Харин Хаан банк, Төрийн банк, Худалдаа Хөгжлийн банкны чанаргүй зээлийн түвшин дунджаас бага зэрэг өндөр байна.



Зах зээлийн мэдээлэл

ХАСБАНК ХК 9 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ХУВЬЦАА ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВНА

ХасБанк ХК 2026 оны 7 дугаар сарын 23-наас 2027 оны 7 дугаар сарын 22-ны өдрийг хүртэл хэрэгжих, 9 тэрбум төгрөг хүртэлх дүнтэй хувьцаа эргүүлэн худалдан авахаар болжээ.

9 тэрбум төгрөгийн хэмжээ ямар ач холбогдолтой вэ?

Тус банкны хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны идэвхийг харвал:

- 2024 он: 6.9 тэрбум төгрөг
- 2025 он: 7.8 тэрбум төгрөг
- 2026 оны эхний хагас жил: 3.3 тэрбум төгрөг

Өөрөөр хэлбэл, энэ удаагийн 9 тэрбум төгрөгийн эргүүлэн худалдан авах санхүүжилт нь өмнөх жилүүдийн нийт хоёрдогч зах зээлийн арилжааны хэмжээтэй дүйцэхүйц том дүн бөгөөд зах зээл дэх нийлүүлэлтийг шингээж, хувьцааны ханшийг тогтворжуулахад бодитой нөлөө үзүүлэх хэмжээний эх үүсвэр гэж үзэж болно.

Эргүүлэн худалдан авах үнэ 1,200 төгрөг. Тэгвэл худалдан авах үнэ ханшид ямар нөлөө үзүүлэх вэ?

2026 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар ХасБанк ХК-ийн хувьцаа 1,146 төгрөгөөр хаагдсан байна.

Эргүүлэн худалдан авах үнийг 1,200 төгрөг гэж тогтоосон нь зах зээлд тодорхой хэмжээний үнийн дэмжлэг бий болгох боломжтой. Ийм хэмжээний хөрөнгөөр нийлүүлэлтийг шингээх нь ханшийг 1,200 төгрөгийн бүсээс доош хүчтэй унах эрсдэлийг бууруулж, цаашлаад зах зээлийн эрэлт сайжрах тохиолдолд өмнөх түүхэн дээд ханш болох 1,335 төгрөг рүү өсөх суурь нөхцөлийг бүрдүүлэх боломжтой гэж үзэж байна.

Эргүүлэн худалдан авах хөтөлбөрийн зорилго

ХасБанк ХК нь жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 2024 оны 9 дүгээр сарын 19-нөөс эхлэн хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөр хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ удаагийн хөтөлбөр нь өмнөх бодлогын үргэлжлэл юм.

Хувьцааг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нээлттэй зах зээлээс худалдан авах бөгөөд дараах нөхцөлөөр хэрэгжинэ.

- Эргүүлэн худалдан авах хувьцааны тоо - 7.5 сая ширхэг хүртэл
- Худалдан авах дээд үнэ - 1,200 төгрөг
- Нийт санхүүжилт - 9 тэрбум төгрөг хүртэл
- Хөтөлбөрийн хугацаа - 2026.07.23 – 2027.07.22 (12 сар)